

Түүх 9 : Петр (Суумгай хүнийг эдгээсэн нь)

Библийн эшлэл
[Үйлс 3:6]

Харин Петр түүнд, - Надад алт, мөнгө байхгүй. Харин өөрт байгаагаа л би чамд өгье гээд – Назарын Есүс Христийн нэрээр босоод явагтун гэж хэлээд.

Нэгэн өдөр Петр, Иохан хоёр залбирахаар сүм рүү явж байв.

Тэр хоёр сүмийн үүдэнд сууж байгаа хүнийг харав.

Тэр хүн төрөлхийн суумгай нэгэн бөгөөд нэг ч удаа алхаж үзээгүй хүн байлаа.

Тэр сүм рүү орж гарч байгаа хүмүүсээс гуйлга гуйж байв.

Петр, Иохан хоёрыг дөхөн ирэхийг хараад суумгай хүн гуйлга гуйв.

Харин Петр, Иохан хоёрт мөнгө байсангүй.

Энэ үед Петр ингэж хэлэв. “Надад алт мөнгөний аль нь ч байхгүй ч өөртөө байгаа зүйлийг өгье.”

Суумгай хүн ямар нэгэн чухал юм өгөх нь дээ гэж бодон гараа тосов.

Петр суумгай хүнд хэлэв. “Назарын Есүс Христийн нэрээр босоод алх!”

Петр түүний баруун гараас өргөөд босгов. Суумгай хүний хөлөнд хүч орохыг мэдэрч өөрийн эрхгүй босов.

Тэр маш их баярлаж яахаа ч мэдэхгүй байлаа.

Тэгээд Петр, Иохан хоёрын араас сүм рүү орж алхаж, гуйж, цовхчин үсэрч Бурханд талархан магтаж байлаа.

Сүмд залбирахаар ирсэн хүмүүс үүнийг хараад бүгд цугларч ирэв.

Петр хүмүүст “Гэмшиж, Бурханд итгэгтүн” гэж хичээнгүйлэн зааж байв.

Үүнээс хойш Петр явсан газар бүрдээ Есүсийн тухай ярьж байв.

Тийм учраас Петрээр дамжуулан маш олон хүмүүс Есүс бол Бурхан Хүү, бидний Аврагч хэмээн итгэж байлаа.





Бүтээлч байцгаа 1.

Хурууны хүүхэлдэй хийгээрэй.

Тэгээд Петрийн түүхийг сонссоныхоо дагуу дүрүүдэд орж тоглоорой.



а. Петр, Иохан хоёр яагаад сүм рүү явсан бэ?

б. Петр, Иохан хоёр Есүсийн нэрээр суумгай нэгэнд юу хийж өгсөн бэ?

с. Үйлс 3:1-10 эшлэлийг уншаад хариулаарай. Суумгай нэгэн эдгэрсний дараа юу хийсэн бэ?

● Дараах эшлэлийг уншаад цээжлээрэй. (Үйлс 3:6)

Харин Петр түүнд – Надад алт, мөнгө байхгүй. Харин өөрт байгаагаа л би чамд өгье гээд –
Назарын Есүс Христийн нэрээр босоод явагтун гэж хэлээд